МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrtd.gov.mn, http://www.mrtd.gov.mn

2022.05.06 № 03/2117

танай ____________-ны № ____________-т

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САНГИЙН ГАЗАРТ

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах дансанд байршиж байгаа үлдэгдлээс хавсралтад заасан "Ти ай би" ХХК-д гэрээний дагуу олгох 14,040,000.0 (арван дөрвөн сая дөчин мянга) төгрөгийн эрхийг зохих журмын дагуу нээж өгнө үү.

Хавсралт 11 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД

9020050420 5519487 СБА7569

080001648

**Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах данснаас барьцаа хөрөнгө олгох жагсаалт**

*2022.05.05* */төгрөгөөр/*

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Гүйцэтгэгч компани | 2021 оны эхний үлдэгдэл | 2021 онд нэмэгдсэн орлого | 2021 онд олгосон дүн | Одоо олгох дүн | Үлдэгдэл | Гэрээний заалт | Шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Эрх нээлгэх нийт дүн** | | **14,040,000.0** | **0.0** | **0.0** | **14,040,000.0** | **0.0** | | |
| 1 | Өгийнуур-батцэнгэл-их тамир 104 км зураг төсөл | "Ти Ай Би" ХХК | 14,040,000.00 | | | 14,040,000.0 | 0.0 | *Тусгай нөхцлийн 7.4.(4).* Барилгын улаан шугам хүлээлцэх үед зураг төслөөс шалтгаалсан зөрчил гологдол үүсээгүйг гүйцэтгэгч хүлээн зөвшөөрсөн, эсхүл барилгын ажил эхлэлгүй 2 жил өнгөрсөн тохиолдолд энэхүү гэрээнд үндэслэн Зөвлөхөд олгоно. | 2013.02.07-ны өдрийн 81/2013 дугаартай Магадлалын ерөнхий дүгнэлт, 2013.02.17-ны өдрийн Зураг төсөл хүлээлцсэн акт, |

Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Д.Гэрэлням

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн дарга Ч.Ренчиндамба

Боловсруулсан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн шинжээч Н.Баярсайхан

ТИ АЙ БИ ХХК

2022.05.02 № 04/53 Улаанбаатар хот

**ЗАМ, ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН ЯАМ-Д**

Төлбөрийн тухай:

Манай байгууллага Захиалагч болох Зам, Тээвэр, Барилга, хот байгуулалтын Яам болон Санхүүжүүлэгч болох Монгол Улсын Хөгжлийн банктай С-АЗ-3 2012-141/02 тоот "**ӨГИЙНУУР-БАТЦЭНГЭЛ-ИХ ТАМИР ЧИГЛЭЛИЙН 104КМ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**"-г **2012** оны **09** дүгээр сарын **05**-ны өдөр байгуулсан.

Зураг төслийг хүлээлгэн өгөхдөө **2013** оны **02** дугаар сарын **07**-ны өдрийн гэрээ дүгнэсэн АКТ-аар баримтжуулсан болно. **АКТ№01/2013 2013** оны **02** дугаар сарын **17**.

Гэрээний тусгай нөхцөлийн 7.4.(4)-т "**Нийт төсөвт өртгийн 5%-тай тэнцэх дүнг** тухайн зам барилгын ажил эхлэн улаан шугам хүлээлцэхэд зураг төслөөс шалтгаалсан зөрчил доголдол үүсээгүйг Барилгын гүйцэтгэгч хүлээн зөвшөөрсөн эсхүл **барилгын ажил эхлэлгүй 2 жил өнгөрсөн тохиолдолд энэхүү гэрээнд үндэслэн Зөвлөхөд олгоно**" гэж заасан.

Гэрээний дүн **280 800 000.0₮**-ийн **5%** болох **14 040 000.0₮** төгрөгийг дээрх нөхцөлүүдийг тооцон манайд олгоно уу.

**Хавсралт:** Зөвлөхийн гэрээний хувь, Зураг төслийн нүүр болон магадлангийн тайлан, Гэрээ дүгнэсэн АКТ, Зураг төсөл хүлээлцсэн АКТ.

Харилцах банк: **Хаан**, данс **5034176140 "Ти Ай Би" ХХК**

Хүндэтгэсэн:

Захирал ............................ /Б.Түшигсайхан/

ТИ АЙ БИ ХХК
ТТБ 2465
5107822
УЛААНБААТАР ХОТ

УлаанбаатархотТел: 99112869, 99102869

E-mail: namshirc@yahoo.com namshir225@gmail.com

| | |
|---|---|
| | (4) Зам барилгын ажлыг гүйцэтгэх явцад Зөвлөхийн боловсруулсан зураг төслөөс шалтгаалан гарсан аливаа алдаа дутагдлыг өөрийн хөрөнгөөр Захиалагчийн заасан хугацаанд засах бөгөөд үүнээс үүсэх эрсдэлийг хүлээнэ;<br>(5) Зураг төсөл боловсруулах ажлын Зөвлөх нь зам барилгын ажил эхлэхэд өөрийн зардлаар зам барилгын ажлын гүйцэтгэгчид улаан шугам хүлээлгэн өгч, акт үйлдэн Захиалагчид хүлээлгэн өгнө;<br>(6) Зөвлөх нь инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг мэргэжлийн болон ёс суртахууны өндөр түвшинд, үнэнч шударгаар чанартай хийх үүрэгтэй;<br>(7) Зөвлөх нь боловсруулсан инженерийн нарийвчилсан зураг төслийг Улсын экспертизээр баталгаажуулан захиалагчид ирүүлэх бөгөөд ажил хүлээлцсэн акт үйлдсэн байна. |
| 3.5 | Зөвлөх нь шаардлагатай бүх даатгалыг өөрийн зардлаар хариуцна. Гэрээнд гарын үсэг зурснаас 14 хоногийн дотор даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагч, санхүүжүүлэгчид ирүүлнэ. Хэрэв Зөвлөх энэ хугацаанд даатгалын гэрээг байгуулаагүй бол Санхүүжүүлэгч даатгалын гэрээг Зөвлөхийн өмнөөс хийж, гарсан зардлыг Зөвлөхөд төлөх төлбөрөөс хасч тооцно. |
| 3.7 (3) | Гэрээний бусад нөхцөлд өөрчлөлт оруулах тохиолдолд. |
| 3.8 | Алданги ноогдуулах: *Хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн 0.25 хувийн алданги ноогдуулна. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэх тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээ авна.* |
| 4.6 | Төслийн удирдагч нь төслийн хугацаанд Монгол улсад байрлан үйл ажиллагаа явуулна. |
| 5.1(7) | Захиалагчийн зүгээс Зөвлөхөд доорхи бусад дэмжлэг, тусламжийг үзүүлнэ. Үүнд:<br>*Захиалагч нь зураг төслийг боловсруулахад шаардагдах техникийн нөхцлийг бүрдүүлэх, техникийн нөхцөлд тодруулга оруулах, зураг төслийг Улаанбаатар хотын харьяа байгууллагуудаар хянуулах, зөвшөөрөлцөхөд Зөвлөхөд тусламж дэмжлэг үзүүлж хамтран ажиллана. Захиалагчийн зүгээс шугам сүлжээний агентлагуудад албан тоотоор хандаж техникийн нөхцлийг хүснэ. Үүний дагуу Зөвлөх болон туслан гүйцэтгэгч нь шугам сүлжээний агентлагтай зөвшилцөж, техникийн нөхцлийг гаргуулж авна.*<br>*Шугам сүлжээний зураг төсөл боловсруулах зөвлөхүүд нь бие даан шаардлагатай зураг төслийг боловсруулж, улмаар тухайн шугам сүлжээний агентлагт хандаж зөвшилцөн батлуулах байдлаар ажлын зургийг иж бүрэн боловсруулах үүрэгтэй.*<br>*Шугам сүлжээ, геологийн бүх ажил тусдаа экспертизээр орж баталгаажна.* |
| 7.1(2) | Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: ***280 800 000 ₮ (Хоёр зуун наян сая найман зуун мянган төгрөг)*** |
| 7.2 | Нэмэлт ажлын хөлс, нөхөн төлбөрийг Захиалагч улсын төсөвт тусгана. Гэрээний үнээс нэмэгдсэн зардалд Санхүүжүүлэгч хариуцлага хүлээхгүй. |
| 7.3 | Гэрээний дагуу бүх төлбөр нь ***төгрөгөөр*** хийгдэнэ. |
| 7.4(1) | (1) Урьдчилгаа төлбөр: гэрээний үнийн *30% -тай* тэнцэх урьдчилгаа төлбөрийг түүнтэй тэнцэх Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргасан тохиолдолд олгоно.<br>(2) Нийт ажлын геодези, геологийн судалгаа хийж, Байр зүйн зураглал, Трассын сонголт төлөвлөлт, Гүүрийн төлөвлөлтийн тайланг Захиалагчаар батлуулан Санхүүжүүлэгчид хүргүүлэхэд 30 хувьтай тэнцэх дүнг олгоно. (Урьдчилгаа төлбөр төлсөн тохиолдолд 20% байна) |

| | |
|---|---|
| | (3) Бусад шугам сүлжээг төлөвлөн, Ажлын зургийн сүүлийн зөвшилцөл хийж, иж бүрэн зураг төсөвийг Улсын экспертизээр батлуулвал 65 хувьтай тэнцэх дүнг олгоно. Энэ нь сүүлчийн төлбөр болно. (Урьдчилгаа төлбөр төлсөн тохиолдолд 45% байх бөгөөд Урьдчилгаа төлбөрийн баталгааг Зөвлөхөд буцаана.)<br>(4) Нийт төсөвт өртгийн 5 хувьтай тэнцэх дүнг тухайн зам барилгын ажил эхлэн улаан шугам хүлээлцэхэд зураг төслөөс шалтгаалсан зөрчил доголдол үүсээгүйг Барилгын ажлын гүйцэтгэгч хүлээн зөвшөөрсөн эсхүл барилгын ажил эхлээгүй 2 жил өнгөрсөн тохиолдолд энэхүү гэрээнд үндэслэн Зөвлөхөд олгоно. |
| 7.4(4) | Төлбөр хийх данс: *Хөгжлийн банк 3600000024* |

**БАТЛАВ**

| САНХҮҮЖҮҮЛЭГЧ | ЗАХИАЛАГЧ | ЗӨВЛӨХ |
|---|---|---|
| Монгол Улсын Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал | Зам, Тээвэр, Барилга, Хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга бөгөөд төсвийн ерөнхий менежер | "Ти Ай Би" ХХК-ийн ...захирал |
| КИМ ЖАН ЖИН | Ж.БАТ-ЭРДЭНЭ | Б.ҮНШИН САЙХАН |

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК

## I. ГЭРЭЭ

## ӨГИЙНУУР-БАТЦЭНГЭЛ-ИХ ТАМИР ЧИГЛЭЛИЙН 104 КМ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

Дугаар № C-A3-3 2012-141/02.

2012 оны 09 сарын 05-ны өдөр Улаанбаатар хот

Нэг талаас *Зам, Тээвэр, Барилга, Хот байгуулалтын яам* (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас *" Ти Ай Би " ХХК* (цаашид "Зөвлөх" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож *2012* оны .... дугаар сарын ....-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "Гэрээ" гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1-д тодорхойлсон "Техникийн даалгавар"-т заасан зөвлөх үйлчилгээг (цаашид "үйлчилгээ" гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь Захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь *Өгийнуур-Батцэнгэл-Их тамир чиглэлийн 104 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, дугаар №.........*-г (цаашид "ажил" гэх) *280 800 000 ₮ (Хоёр зуун наян сая найман зуун мянган төгрөг)* (цаашид "гэрээний үнэ" гэх) үйлчилгээг үзүүлэхээр Зөвлөхийн ирүүлсэн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;
Хавсралт

| | |
|---|---|
| Хавсралт №1 | Техникийн даалгавар |
| Хавсралт №2 | Тайлан гаргах хуваарь |
| Хавсралт №3 | Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарь |
| Хавсралт №4 | Төгрөгөөр тодорхойлсон төсөвт өртөг |
| Хавсралт №5 | Захиалагчийн үзүүлэх үйлчилгээ, байгууламж |
| Хавсралт №6 | Зөвлөхийн түншлэлийн гэрээ |
| Хавсралт №7 | Гэрээний хэлцэл хийсэн тэмдэглэл |

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.

5. Захиалагч, Санхүүжүүлэгч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

6. Зөвлөх нь гэрээний дагуу Санхүүжүүлэгчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн гэрээнд заасан үйлчилгээг гүйцэтгэж, зөрчил, доголдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, доголдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

Гэрээтэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, хүсэлтийг талууд дараахь албан ёсны хаягаар албан бичгээр хүргүүлнэ.

| САНХҮҮЖҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ | ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ | ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ |
|---|---|---|
| *Монгол Улсын Хөгжлийн банкны Зээлийн газрын захирал* | *Зам, Тээвэр, Барилга, Хот байгуулалтын яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга* | *"Алтай хилл" ХХК-ийн Ерөнхий Инженер* |
| | Г.МӨНХБИЛЭГ | |
| *Хаяг:* | | *Хаяг:* |
| *Засгийн газрын II байр Нэгдсэн Үндэстний гудамж 5 Чингэлтэй дүүрэг Улаанбаатар 15160 Монгол Улс* Утас: +976-70-130216 Факс: +976-70-130602 | *Зам, Тээвэр, Барилга, Хот байгуулалтын яамны Сайдын багцын ерөнхий нягтлан бодогч* Д.ДОЛГОРСҮРЭН АЗГ-ын өрлөгийн дарга ... АЗГ-ын ... хүний Секторын эрхлэгч Я.БАЯРХҮҮ *Хаяг: УБ хот ЧД, Барилгачдын талбай3, Утас:31-06-12, факс( 976-11 )32-29-04* | *Улаанбаатар хот БГД, 8-р хороо, Чингүнжавын гудамж-21 №201,202 тоот Утас:976-99102869 976-88020066 976-11-362048* |

УЛААНБААТАР ХОТ МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК

АЛТАЙ ХИЛЛ ХХК ... Л.НАМШИР

**ӨГИЙНУУР – БАТЦЭНГЭЛ - ИХТАМИР ЧИГЛЭЛИЙН 130,6 км ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ**

2013 оны 02 дугаар сарын 07 өдөр Улаанбаатар хот

Өгийнуур-Батцэнгэл-Их тамир чиглэлийн 130,6 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 280 800 000 /Хоёр зуун наян сая найман зуун мянга/ төгрөгөөр гүйцэтгэхээр 2012 оны 9 дүгээр сарын 5- ны өдөр С-АЗ-з 2012-141/02 тоот гэрээ байгуулсан.

Уг ажлыг Авто замын газрын баталсан зураг төсөл зохиох техникийн даалгаврын дагуу хийж гүйцэтгэн, улсын эксперт Монгол улсын зөвлөх инженер И.Гончигзэвгээр баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгөв. Үүнд :
Инженерийн нарийвчилсан зураг төслийг:

- Ажлын зураг 4%
- Тайлбар бичиг 4%
- Техникийн шаардлага 4%
- Геологийн тайлан 4%
- Геодезийн тайлан 4%
- Ажлын тоон хэмжээн нарийвчилсан хүснэгт 4%
- Барилгын ажлын төсөв 1% */ Битүүмжилсэн байдлаар/*
- CD бичлэг 4%
- Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ 2%
- Ус зүйн судалгааны тайлан 4%
- Археогийн судалгааны тайлан 2%
- Танилцуулга 2%

Өгийнуур-Батцэнгэл-Их тамир чиглэлийн 130,6 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг 280 800 000 /Хоёр зуун наян сая найман зуун мянга/ төгрөгөөр снхүүжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Захиалагчийг төлөөлж:

Зам, тээврийн яамны АЗБХЗГ-ын
замын барилгын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
Х.ГАНБОЛД

Зам, тээврийн яамны Санхүү хөрөнгө
хэлтсийн оруулалтын мэргэжилтэн
Н.БАЯРСАЙХАН

Авто замын хяналт, эрдэм шинжилгээ,
судалгааны төвийн орлогч дарга
Х.ГАНТӨМӨР

АЗБХЗГ-ын Замын барилгын
үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
Д.ЭНХТУЯА

Гүйцэтгэгчийг төлөөлж:

"Ти Ай Би" ХХК-ний захирал
Б. ТҮШИГСАЙХАН

"Ти Ай Би" ХХК-ний ерөнхий инженер
Ч. НАМШИР

# ГЭРЭЭТ ЗУРАГ ТӨСЛИЙН АЖИЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН ТУХАЙ АКТ

## № 01/2013

2013 оны 02 дугаар сарын 17-ны өдөр

Захиалагч Зам, тээврийн яам, Санхүүжүүлэгч Монгол Улсын Засгийн газар, Гүйцэтгэгч “Гео зураглал” ХХК-ийн хооронд байгуулсан “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэрээгээр харилцан үүрэг хүлээж гүйцэтгэсэн “Өгийнуур-Батцэнгэл-Их тамир чиглэлийн 130,6 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл”-ийг бүрэн дуусгаж хүлээлгэж өгөв.

Үүнд:

- Ажлын зураг 4%
- Тайлбар бичиг 4%
- Техникийн шаардлага 4%
- Геологийн тайлан 4%
- Геодезийн тайлан 4%
- Ажлын тоон хэмжээн нарийвчилсан хүснэгт 4%
- Барилгын ажлын төсөв 1% */ Битүүмжилсэн байдлаар/*
- CD бичлэг 4%
- Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ 2%
- Ус зүйн судалгааны тайлан 4%
- Археоогийн судалгааны тайлан 2%
- Танилцуулга 2%

Хүлээн авсан:

Зам, тээврийн яамны АЗБХЗГ-ын замын барилга үйлдвэрлэлийн хэлтсийн дарга — Х.ГАНБОЛД

Зам, тээврийн яамны АЗБХЗГ-ын Замын барилга үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн — Д. ЭНХТУЯА

Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, Судалгааны төвийн орлогч захирал — Х.ГАНТӨМӨР

Хүлээлгэж өгсөн:
“Ти Ай Би” ХХК-ний ерөнхий нженер — Ч. НАМШИР

ТИ АЙ БИ ХХК
ТТГ 2465
4307822
УЛААНБААТАР ХОТ

**ӨГИЙНУУР- БАТЦЭНГЭЛ - ИХТАМИР ЧИГЛЭЛИЙН 130,6 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

Зургийн байгууллага: “Ти Ай Би” ХХК

| № | Зардлын нэр | Гэрээний үнэ /төг/ |
|---|---|---|
| | ***Шууд зардал*** | |
| 1 | *Замын хайгуул* | *85 500 000.0* |
| 2 | *Гүүрийн хайгуул* | |
| 3 | *Замын зураг төсөл* | *86 874 186.2* |
| 4 | *Гүүрийн зураг төсөл* | |
| 7 | *Төслийн хураангуй танилцуулга* | *100 000.0* |
| | ***ДҮН*** | ***172 474 186.20*** |
| 8 | *Экспертизийн зардал 2-4%* | *3 474 967.45* |
| 9 | *Норм, нормативын сан 0.18%* | *310 453.54* |
| 10 | *Захиалагчийн зардал 2%* | *3 449 483.72* |
| | ***ДҮН*** | ***179 709 090.91*** |
| 11 | *НӨАТ 10%* | *17 970 909.09* |
| | ***ДҮН*** | ***197 680 000.0*** |
| 12 | *Инженер геологийн судалгаа, тайлан* | *39 520 000.0* |
| 13 | *Геодезийн байр зүйн зураг,тайлан* | *41 600 000.0* |
| 14 | *Цахилгаан , гэрэлтүүлгийн зураг, тайлан* | |
| 18 | *Гидротехникийн байгууламжийн зураг, тайлан* | *2 000 000.0* |
| **НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ** | | ***280 800 000.0*** |
| **ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛЭЭР САНХҮҮЖИЛТ** | | |

**Гүйцэтгэлээр санхүүжигдэх дүн нь 280 800 000 ₮ (Хоёр зуун наян сая найман зуун мянга) төгрөг болно.**

Захиалагчийг төлөөлж:

Зам, тээврийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
З.ЦЭРЭНЧИМЭГ

Зам, тээврийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
Н.БАЯРСАЙХАН

Зам, тээврийн яамны АЗБХЗГ-ын Зам барилгын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
Х.ГАНБОЛД

Зам, тээврийн яамны АЗБХЗГ-ын зам барилгын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн
Д.ЭНХТУЯА

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Ти Ай Би” ХХК-ний захирал
Б. ТҮШИГСАЙХАН

“Ти Ай Би” ХХК-ний ерөнхий инженер
Ч. НАМШИР

“Ти Ай Би” ХХК-ий менежер
Ч.БУДМАА

"Ти Ай Би" ХХК

# Өгий нуур – Батцэнгэл – Ихтамир чиглэлийн 130 км хатуу хучилттай авто зам

**Захиалагч:**"Зам тээврийн яам"

Шифр №04/12

Захирал.......................................Б.Түшигсайхан

2012 он УБ хот

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

**БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ**

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

# МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2013 оны 02 дугаар сарын 07 өдөр

Дугаар 81/2013

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс: 976-11-320338

| | |
|---|---|
| **Объектын нэр:** | Өгийнуур – Батцэнгэл - Их тамир сум чиглэлийн 130.6 км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл |
| **Объектын байршил:** | Архангай аймгийн Өгийнуур – Батцэнгэл - Их тамир сумууд |
| **Хүчин чадал:** | 130.6 км хатуу хучилттай авто зам |
| **Захиалагч:** | Зам, тээврийн Яам |
| **Санхүүжилтийн эх үүсвэр:** | Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар |
| **Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр,** | “Ти Ай Би” ХХК |
| **Регистрийн дугаар:** | РД: 5107822 |
| **Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:** | 2013.07.22 хүртэл |

**Зураг төсөл боловсруулах үндэслэл:**

| | |
|---|---|
| Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо: | Архангай аймгийн Өгийнуур сумын Засаг даргын 2012 оны 11-р сарын 27-ны өдрийн а/90 тоот, мөн аймгийн Батцэнгэл сумын Засаг даргын 2012 оны 11-р сарын 27-ны өдрийн а/108 тоот болон Их тамир сумын Засаг даргын 2012 оны 10 сарын 22-ны өдрийн 98 тоот захирамж |
| Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Авто замын газрын дарга Б.Энхтөрийн 2011 оны 02 сарын 02-ны өдөр баталсан 14/11 тоот зургийн даалгавар |
| Зураг төслийн гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо: | Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Хөгжлийн банк, “Ти Ай Би” ХХК-ийн хооронд байгуулсан 2012 оны 09 сарын 05-ны өдөр баталсан № С-АЗ-3 2012-141/02 тоот гэрээ |

**Техникийн нөхцлүүд:**

| Техникийн нөхцлүүд: | Олгосон байгууллага | Дугаар, огноо | Хүчинтэй байх хугацаа |
|---|---|---|---|
| - | - | - | - |

Зөвшөөрөлцсөн байгууллагууд:

| | |
|---|---|
| Архангай аймгийн Их тамир сумын засаг дарга | Ц.Мөнхбат |
| Архангай аймгийн Өгийнуур сумын засаг дарга | Б.Нямдаваа |
| Архангай аймгийн Батцэнгэл сумын засаг дарга | Я.Батгэрэлсайхан |

**Зураг төслийн бүрэлдэхүүн:**

| Зургийн бүрдэл: | Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр | Шалгасан экспертийн нэр |
|---|---|---|
| Ажлын зургийн тайлбар бичиг, | “Ти Ай Би” ХХК | И.Гончигзэвэг |

| | | |
|---|---|---|
| хучилт болон хиймэл байгууламжийн тооцоо | | |
| Авто замын ажлын зураг /хиймэл байгууламжийн хамт/ | "Ти Ай Би" ХХК | И.Гончигзэвэг |
| Хөндлөн огтлолын зураг | "Ти Ай Би" ХХК | И.Гончигзэвэг |
| Техникийн шаардлага | "Ти Ай Би" ХХК | И.Гончигзэвэг |
| Төсөв | төсөвчин Д.Энхбаатар | Да.Энхтуяа |
| Инженер-геологийн судалгаа | "Жонщт-Уул" ХХК Архив № 1887 | Дүгнэлт баталгаажсан |

Ерөнхий дүгнэлт: */Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлээс/*

| | |
|---|---|
| Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдлийн болон техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт; | ***Барилга байгууламжийн хүчин чадал:***<br>Архангай аймгийн Өгийнуур – Батцэнгэл - Их тамир сумдын нутаг дэвсгэрийг хамарсан Дашинчилэн - Өгийнуур чиглэлийн авто замын төгсгөлөөс Батцэнгэл сумыг дайруулан Их тамир сумын төвд Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замтай холбохоор төлөвлөж буй 130.6 км асфальтобетон хучилттай авто зам нь 181 цэгт төмөр бетон хоолой, 3 цэгт дамжих хавтан бүхий хоолой төлөвлөсөн нь холбогдох норм дүрмийн шаардлага хангасан гэж эксперт дүгнэсэн байна.<br>***Төлөвлөлт:***<br>Төлөвлөж буй авто зам нь 130.6 км урттай, далангийн өргөн 11.0 метр, 7.0 метрийн өргөн зорчих хэсэг, 2.0 м өргөн хөвөөний 0.5 метр нь бэхэлгээтэй,<br>Өнгө асфальтобетон хучилт - 30 мм<br>Суурь асфальтобетон хучилт - 40 мм<br>Цемэнтээр бэхжүүлсэн зохист<br>найрлага бүхий суурь - 200 мм<br>Суурийн доод үе – 200 мм<br>Хөлдөлтөөс хамгаалах үе – 300 мм<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцлийг хангасан шийдлийг тусгах шаардлагагүй гэж үзсэн байна.<br>***Техник технологи, дэд бүтцийн хангамж***<br>Авто замын трасст орсон цахилгааны шугамыг шилжүүлэх, өндөрлөх техникийн нөхцлийг холбогдох мэргэжлийн байгууллагаас авч, зураг төслийг боловсруулан магадлал хийлгэх шаардлагатай |
| Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаархи тодорхой санал, дүгнэлт; | **Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдлийг орон тооны бус эксперт шалгаад:**<br>III зэргийн замын тооцоот хурд хэрчигдсэн газраар тавигдсан хэсэгт огтлолын дээд хэмжээ 60 хувиас хэтрүүлснийг засч тоо хэмжээг өөрчлөх, шаардлагагүй зарим цэгт хоолойнуудыг хасах, замын далангийн 2 талаар 4.0 м-ээс багагүй өргөн дэвсэг гаргах зэрэг засвар өөрчлөлтүүдийг хийх шаардлага тавьсаны дагуу засварыг хийж, тоо хэмжээг төсөвт өөрчилж засварласан байна. |
| Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн | Төсөл хэрэгжсэнээр Архангай аймгийн байгалийн цогцолбор газарт аялал жуулчлалын чиглэлээр иргэдийн ая тухтай зорчих нөхцөл бүрдэж, замын дагуух орон нутгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулахаас гадна орон нутгийн байгаль орчин, тоосжилт, хөрсний бохирдлыг үлэмж хэмжээгээр бууруулах нэн чухал ач холбогдолтой. |

| | |
|---|---|
| ач холбогдол зэргийг харгалзан гаргасан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаархи дүгнэлт. | |
| Төсөвт өртөг: | "Архангай аймгийн Өгийнуур – Батцэнгэл – Их тамир чиглэлд баригдах 130,6 км хатуу хучилттай замын барилгын ажлын төсөв"-ийг орон тооны бус эксперт 92 129 390 946 (Ерэн хоёр тэрбум нэг зуун хорин есөн сая гурван зуун ерэн мянга есөн зуун дөчин зургаан) төгрөгөөр хянасан байна. |

**Барилгын тухай" хуулийн 13.4-т заасны дагуу "Зураг төсөл зохиогчийн гаргасан алдааг зураг төслийн байгууллага, зохиогч хариуцах ба магадлал хийсэн этгээд зураг төслийн техникийн шийдлийн талаар гаргасан дүгнэлтийнхээ төлөө хариуцлагыг хүлээнэ."**

Архангай аймгийн Өгийнуур – Батцэнгэл – Их тамир чиглэлд баригдах 130.6 км хатуу хучилттай замын инженерийн нарийвчилсан зураг төсөлд "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм"-ийн дагуу орон тооны бус экспертүүд магадлал хийсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь экспертүүдийн хавсралт дүгнэлтийн хамт хүчинтэй

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ /Б.БАЯРСАЙХАН/

ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /Н.БАТЖАРГАЛ/

ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /Л.ЭНХТУЯА/

ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН /Д.БАТБААТАР/